

**АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ГАРЧИГ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

- 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт
- 2 дугаар зүйл. Автотээврийн тухай хууль тогтоомж
- 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ
- 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Тээвэрлэлт

- 5 дугаар зүйл. Тээвэрлэлтийн төрөл
- 6 дугаар зүйл. Тээвэрлэлтийн ангилал, зохицуулалт
- 7 дугаар зүйл. Тээвэрлэлтийг түр хугацаагаар зогсоох, хязгаарлах
- 8 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн дайчилгаа
- 9 дүгээр зүйл. Тээвэрлэлтийн баримт бичиг
- 10 дугаар зүйл. Тээвэрлэлтийн даатгал
- 11 дүгээр зүйл. Тээвэрлэлтийн үнэ хөлс
- 12 дугаар зүйл. Тээвэр зуучлал
- 13 дугаар зүйл. Тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгчид тавигдах нийтлэг шаардлага
- 14 дүгээр зүйл. Тээвэрлэгчийн эрх, үүрэг

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Зорчигч тээвэрлэлт

- 15 дугаар зүйл. Зорчигч тээвэрлэгчийн үүрэг
- 16 дугаар зүйл. Зорчигчийн эрх, үүрэг
- 17 дугаар зүйл. Нийтийн зорчигч тээврийн төлбөрийн цахим систем

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Ачаа тээвэрлэлт

- 18 дугаар зүйл. Ачаа тээвэрлэгчийн үүрэг
- 19 дүгээр зүйл. Тээвэрлүүлэгчийн эрх, үүрэг

ТАВДУГААР БҮЛЭГ

Автотээврийн терминал

- 20 дугаар зүйл. Автотээврийн терминал
- 21 дүгээр зүйл. Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Автотээврийн хэрэгслийн ашиглалт

- 22 дугаар зүйл. Авто үйлчилгээ эрхлэгч
- 23 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн бүртгэл

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Салбарын ажилтны давтан болон мэргэжлийн зэрэг олгох сургалт

- 24 дүгээр зүйл. Зөвлөх, мэргэшсэн инженер
- 25 дугаар зүйл. Мэргэшсэн жолооч
- 26 дугаар зүйл. Мэргэшсэн жолоочийн эрх дуусгавар болох
- 27 дугаар зүйл. Мэргэшсэн жолоочийн эрхийг түдгэлзүүлэх

НАЙМДУГААР БҮЛЭГ

Автотээврийн мэдээллийн нэгдсэн сан

- 28 дугаар зүйл. Автотээврийн мэдээллийн нэгдсэн сан

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Автотээврийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх

- 29 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх
- 30 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх
- 31 дүгээр зүйл. Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
- 32 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

АРАВДУГААР БҮЛЭГ

Автотээврийн стандартчилал

- 33 дугаар зүйл. Стандартчилал

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Тусгай зөвшөөрөл

- 34 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл
- 35 дугаар зүйл. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох
- 36 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх үйл ажиллагаа эрхлэх

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэл

37 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэл
38 дугаар зүйл. Автомашины эд ангийн устгал

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Автотээврийн хяналт

39 дүгээр зүйл. Автотээврийн хяналтыг хэрэгжүүлэх
40 дүгээр зүйл. Автотээврийн улсын хяналт
41 дүгээр зүйл. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналт
42 дугаар зүйл. Автотээврийн үйлчилгээ эрхлэгчийн дотоод хяналт
43 дугаар зүйл. Автотээврийн хяналтын улсын байцаагч

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

44 дүгээр зүйл. Автотээврийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх
хариуцлага
45 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Автотээврийн тухай хууль тогтоомж

2.1. Автотээврийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Авто замын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан эрх зүйн хэм хэмжээний бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт автотээвэртэй холбогдох бүх төрлийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна.

3.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад улсын иргэн, хуулийн этгээд автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагааг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулиар зохицуулна.

3.3. Тээвэрлэлтийн тусгай горим шаардсан бараа, бүтээгдэхүүн тээвэрлэхтэй холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар, бусад харилцааг тус тусын хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “автотээвэр” гэж зорчигч болон ачаа тээвэрлэлт, автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон цогц үйл ажиллагааг;

4.1.2. “тээвэрлэлт” гэж автотээврийн хэрэгслээр зорчигч болон ачааг нэг газраас нөгөө газарт шилжүүлэн зөөхтэй холбогдсон ажил, үйлчилгээг;

4.1.3. “автотээврийн хэрэгсэл” гэж авто замаар зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, чиргүүл, хагас чиргүүлийг;

4.1.4. “тээврийн хэрэгсэл” гэж Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг;

4.1.5. “зорчигч” гэж тээврийн хэрэгслээр зорчиж яваа хүнийг;

4.1.6. “ачаа” гэж тээврийн хэрэгслээр тээвэрлэж буй эд зүйлсийг;

4.1.7. “тээвэрлүүлэгч” гэж ачаа илгээгч болон ачаа хүлээн авагчийг;

4.1.8. “тээвэрлэгч” гэж тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг;

4.1.9. “улс хоорондын тээвэр” гэж Монгол Улсын хилийг нэвтрэн хийх тээвэрлэлтийг;

4.1.10. “дамжин өнгөрөх тээвэр” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээвэрлэлтийг;

4.1.11. “хот хоорондын тээвэр” гэж нийслэлээс аймаг, хот, хилийн боомт хүртэл, аймаг, хот болон хилийн боомтоос нийслэл хүртэл хийгдэх тээвэрлэлтийг;

4.1.12. “орон нутгийн тээвэр” гэж аймаг, хотуудын хооронд болон тухайн аймаг, сумын нутаг дэвсгэрт хийх тээвэрлэлтийг;

4.1.13. “хот доторх болон хот орчмын тээвэр” тухайн хотын нутаг дэвсгэрт хийх тээвэрлэлтийг;

4.1.14. “байнгын тээвэр” гэж тодорхой цагийн хуваарь, чиглэлийн дагуу гүйцэтгэж байгаа тээвэрлэлтийг;

4.1.15. “байнгын бус тээвэр” гэж энэ хуулийн 4.1.14-т зааснаас бусад тээвэрлэлтийг;

4.1.16. “нийтийн тээвэр” гэж эрх бүхий байгууллагаас тогтоосон чиглэл, замналын дагуу зохион байгуулалттай гүйцэтгэж байгаа тээвэрлэлтийг;

4.1.19. “мэргэшсэн жолооч” гэж тээвэрлэлтийн тодорхой ажил үйлчилгээ эрхлэх зорилгоор мэргэжлийн үнэмлэх авсан жолоочийг;

4.1.20. “техникийн хяналтын үзлэг” гэж тээврийн хэрэгслийн техникийн байдлыг стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд үзлэг хийж шалгах, тодорхойлох, үнэлэх үйл ажиллагааг;

4.1.21. “автотээврийн хэрэгслийн ашиглалт” гэж тээврийн хэрэгслийг хадгалах, техникийн үйлчилгээ, засвар хийх, шатахуун, тосолгооны болон ашиглалтын бусад материалаар хангах, техникийн бүрэн бүтэн байдал, найдварт ажиллагааг хангахад чиглэгдсэн техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг;

4.1.21. “автотээврийн дэд бүтэц” гэж автотээврийн хэрэгслийн ашиглалтын аюулгүй байдал, тээвэрлэлтийн үйл ажиллагааг үр ашигтай, тасралтгүй хангахад зориулагдсан авто зам, замын байгууламж, ачаа, зорчигчийн терминал, автобус, таксины зогсоол, талбай, авто замын дагуух нийтийн үйлчилгээний цогц байгууламжийг;

4.1.22. “ачаа, зорчигчийн терминал” гэж зорчигч хүлээн авах, үдэн гаргах, буулгах, суулгах, ачааг цуглуулах, хадгалах, савлах, ангилах, ачиж буулгахтай холбогдсон цогц үйлчилгээ үзүүлэх байгууламжийг;

4.1.23. “мөсөн замын тээвэр” гэж гол, мөрөн, нуурын ус хөлдсөн үед тогтоосон хугацаанд мөсөн дээгүүр хийх тээвэрлэлтийг;

4.1.24. “автомашин эд ангийн устгал, дахин боловсруулалт” гэж ашиглалтын хугацаа дууссан буюу стандартын шаардлага хангахгүй болсон тээврийн хэрэгслийн эд ангийг технологийн дагуу устгах, сэргээн засварлах үйл ажиллагааг;

4.1.25. “автомашин үйлдвэрлэл” гэж тээврийн хэрэгсэл, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, зураг төсөл боловсруулах зэрэг автомашин үйлдвэрлэлтэй холбоотой цогц үйл ажиллагааг хэлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Тээвэрлэлт

5 дугаар зүйл. Тээвэрлэлтийн төрөл

5.1. Тээвэрлэлт нь дор дурдсан төрөлтэй байна:

5.1.1. зорчигч тээвэрлэлт;

5.1.2. ачаа тээвэрлэлт.

6 дугаар зүйл. Тээвэрлэлтийн ангилал, зохицуулалт

6.1. Тээвэрлэлтийг нутаг дэвсгэрийн хүрээгээр нь дор дурдсан байдлаар ангилна:

6.1.1. улс хоорондын тээвэрлэлт;

6.1.2. дамжин өнгөрөх тээвэрлэлт;

6.1.3. хот хоорондын тээвэрлэлт;

6.1.4. орон нутгийн тээвэрлэлт;

6.1.5. хот доторх болон хот орчмын тээвэрлэлт.

6.2. Тээвэрлэлтийг давтамжаар нь байнгын болон байнгын бус гэж ангилна.

6.3. Улс хоорондын болон дамжин өнгөрөх зорчигч тээвэрлэлтийн чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг олон улсын автотээврийн харилцааны гэрээ, хэлэлцээрийг үндэслэн автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргаж, автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

6.4. Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг аймгийн Засаг даргатай зөвшилцөн автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргаж, автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

6.5. Орон нутгийн зорчигч тээвэрлэлтийн чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга хэрэгжүүлнэ.

6.6. Хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг тухайн аймаг, хотын Засаг дарга гаргах бөгөөд аймаг, нийслэлийн Засаг даргын эрх олгосон байгууллага хэрэгжүүлнэ.

6.7. Тээвэрлэлтийг Иргэний хууль болон энэ хуульд нийцсэн гэрээний дагуу гүйцэтгэнэ.

6.8. Нийтийн зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг зориулалтын, стандартад нийцсэн, зүүн гар талдаа жолооны хүрдтэй, зорчигчийг баруун гар талруугаа буулгаж, суулгах нөхцөлийг хангасан автотээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.

6.9. Хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд шатдаг хий, цахилгаан эх үүсвэрээр ажилладаг автотээврийн хэрэгсэл ашиглана.

7 дугаар зүйл. Тээвэрлэлтийг түр хугацаагаар зогсоох, хязгаарлах

7.1. Байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, гал түймэр зэрэг гэнэтийн аюул тохиолдсон нөхцөлд тээвэрлэлтийн ажлыг түр хугацаагаар зогсоох буюу хязгаарлах шийдвэрийг дараах эрх бүхий албан тушаалтан гаргаж нийтэд мэдээлнэ.

7.1.1. улс, хот хоорондын тээвэрлэлтийн чиглэлд улсын байнгын онцгой комиссын шийдвэр, саналыг үндэслэн автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;

7.1.2. орон нутгийн тээвэрлэлтийн чиглэлд нийслэл, тухайн аймаг, сумын Засаг дарга.

7.2. Хууль тогтоомжид зааснаас бусад үндэслэлээр тээвэрлэлтийн ажлыг зогсоох, хязгаарлах, автотээврийн хэрэгслийг саатуулахыг хориглоно.

8 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн дайчилгаа

8.1. Автотээврийн хэрэгслийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу дайчилж болно.

8.2. Хууль тогтоомжид зааснаас бусад нөхцөлд автотээврийн хэрэгслийг дайчлахыг хориглоно.

9 дүгээр зүйл. Тээвэрлэлтийн баримт бичиг

9.1. Тээвэрлэлтийн баримт бичигт:

9.1.1. жолооны үнэмлэх;

9.1.2. тээврийн хэрэгслийн гэрчилгээ;

9.1.3. тээврийн хэрэгслийн техникийн хяналтын гэрчилгээ;

9.1.4. зорчигчийн дагалдах хуудас;

9.1.5. зорчигчийн тийз, тасалбар;

9.1.6. ачааны дагалдах хуудас тус тус хамарна.

9.2. Автотээврийн хэрэгслээр зорчих тасалбар, ачааны дагалдах хуудас зэрэг тээвэрлэлттэй холбогдсон баримт бичгийг хэвлүүлэх, ашиглах журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10 дугаар зүйл. Тээвэрлэлтийн даатгал

10.1. Тээвэрлэлтийн даатгалд:

10.1.1. тээврийн хэрэгслийн даатгал;

10.1.2. жолоочийн хариуцлагын даатгал;

10.1.3. зорчигчийн амь насны даатгал;

10.1.4. ачааны хариуцлагын даатгал тус тус багтана.

10.2. Хариуцлагын даатгалд даатгуулаагүй бол тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

11 дүгээр зүйл. Тээвэрлэлтийн үнэ хөлс

11.1. Зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ хөлсний хэмжээг оролцогч талуудын тохиролцож байгуулсан гэрээгээр тогтооно.

11.2. Хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

11.3. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын автотээврийн хэрэгслээс авах үйлчилгээний хураамжийн хэмжээг Засгийн газар тогтооно.

11.4. Тээвэрлэлтийн зай, ачааны төрлөөс хамааруулж зорчигч, ачаа тээвэрлэлтийн жишиг тарифыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12 дугаар зүйл. Тээвэр зуучлал

12.1. Байнгын ачаа тээвэрлэлтийг зуучлагчаар дамжуулан эрхэлж болно.

12.2. Зуучлагч нь байнгын ачаа тээвэрлэлт эрхлэгчийг тээвэрлүүлэгчтэй холбон зуучлах, үйл ажиллагааг нь уялдуулах, тээвэрлэлтийн баримт бичгийг зохицуулах, тээвэрлэлтийн явц, аюулгүй байдалд хяналт тавих, тээвэрлэлтээс үүсэх эрсдлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулна.

12.3. Зуучийн үйл ажиллагааг “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу итгэмжлэгдсэн байгууллага гүйцэтгэнэ.

12.4. Зуучлагч, тээвэрлэгч, тээвэрлүүлэгч нарын үйл ажиллагааг уялдуулах, цахим сүлжээгээр холбох зориулалт бүхий бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээ мэдээллийг нэгтгэх, боловсруулах, хадгалах, хамгаалах болон бүртгэл мэдээллийн сүлжээний үйл ажиллагааг мэргэжил арга зүй технологийн хувьд хариуцаж хэвийн ажиллуулах чиг үүргийг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ.

12.5. Энэ хуулийн 12.4-д заасан бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, сүлжээний үйл ажиллагааны болон аюулгүй байдал, хамгаалалтыг журмаар зохицуулна.

13 дугаар зүйл. Тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгчид тавигдах нийтлэг шаардлага

13.1. Тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгч нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

13.1.1. аюулгүй байдлыг хангах;

13.1.2. тээвэрлэлтийг тухайн ангиллын автотээврийн хэрэгслийг жолоодох эрхтэй, мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх;

13.1.3. ачаа, зорчигчийг тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан, зориулалтын автотээврийн хэрэгслээр тав тухтай, аюул, осолгүй тээвэрлэх;

13.1.4. тээвэрлэлтийн үед зорчигчийн амь нас, эрүүл мэнд болон ачаанд аюул, хохирол учруулахгүй байх нөхцөлийг хангах;

13.1.5. өөрийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ, үйл ажиллагааны мэдээ, тайланг тогтоосон үзүүлэлт, загвараар холбогдох байгууллагад хугацаанд нь гаргаж өгөх;

13.1.6. тээврийн хэрэгслийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах, иргэдийн эрүүл мэнд, амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байх стандарт, нөхцөлийг хангасан, зориулалтын, зөвшөөрөгдсөн байр, зогсоол, талбайд тавих;

13.1.7. тээвэрлэлттэй холбоотой үнэн зөв мэдээллээр тээвэрлүүлэгчийг хангах.

14 дүгээр зүйл. Тээвэрлэгчийн эрх, үүрэг

14.1. Тээвэрлэгч нь дараах эрхтэй:

14.1.1. авто замын байгууллагаас авто зам, гүүрийг тээврийн хэрэгсэл зорчиход саадгүй байлгахыг шаардах, авто зам гүүрийн ашиглалтын нөхцөл хангаагүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;

14.1.2. тээврийн хөлс төлөөгүй буюу жолооч, кондуктор шаардахад тээврийн хөлс төлөхгүй байгаа зорчигч мөн тээвэрлэлтийн нөхцлийн дагуу бэлтгээгүй тээшийг тээвэрлэхээс татгалзах;

14.1.3. нийтийн тээврийн хэрэгслийн жолооч нь нийгмийн хэв журам сахих, тээврийн үйлчилгээний дүрэм, журмыг биелүүлэх шаардлагыг зорчигчид тавих.

14.2. Тээвэрлэгч нь энэ хуулийн 15.1, 18.1 дэх заалтад тусгагдсан шаардлагыг хангах үүрэг хүлээнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Зорчигч тээвэрлэлт

15 дугаар зүйл. Зорчигч тээвэрлэгчийн үүрэг

15.1. Зорчигч тээвэрлэгч нь энэ хуулийн 13.1-д заасан нийтлэг шаардлагаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

15.1.1. нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэхдээ эрх бүхий байгууллагаас тогтоосон тээврийн чиглэл, цагийн хуваарийг баримтлах;

15.1.2. хот доторхи болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн хэрэгсэл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тээвэрлэх зориулалтын тоноглолтой байх;

15.1.3 .зөвхөн өөрийн өмчийн автотээврийн хэрэгслээр нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх;

15.1.4. хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд хийн түлш, цахилгаан эх үүсвэрээр ажилладаг болон тэдгээрийн хосолмол хэрэглээ бүхий автотээврийн хэрэгсэл ашиглах.

16 дугаар зүйл. Зорчигчийн эрх, үүрэг

16.1. Зорчигч нь дараахь эрхтэй:

16.1.1. тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангаагүй, зориулалтын бус автотээврийн хэрэгслээр үйлчлүүлэхээс татгалзах;

16.1.2. тогтоосон чиглэл, үйлчилгээний цагийн хуваарь баримтлахыг тээвэрлэгчээс шаардах;

16.1.3. тээвэрлэлтийн үнэ тариф, чиглэл, үйлчилгээний цагийн хуваарийн талаар үнэн зөв мэдээллийг тээвэрлэгчээс авах;

16.1.4. нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр улс болон хот хооронд зорчигч нь хүндэтгэн үзэх шалтгаанаар зорчих боломжгүй болсон буюу хүрэх газартаа хүрээгүй тохиолдолд замын үлдсэн хэсэгт ногдох тээврийн хөлсийг тээвэрлэгчээс буцааж авах;

16.1.5. тээвэрлэлтийн улмаас зорчигчийн амь нас, бие махбод, эд хөрөнгөд учирсан хохирлыг холбогдох хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлэх;

16.1.6. хуульд заасан бусад эрх.

16.2. Зорчигч нь дараахь үүрэг хүлээнэ:

16.2.1. хуульд өөрөөр заагаагүй бол тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхдээ төлбөрөө төлөх;

16.2.2. автотээврийн хэрэгслээр үйлчлүүлэх явцад өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул, эрсдэл учрах нөхцөл байдал үүсгэхгүй байх;

16.2.3. нийтийн тээврээр зорчихдоо автотээврийн хэрэгслийн эд анги, суурилагдсан тоног төхөөрөмжийг эвдэж, гэмтээхгүй байх;

16.2.4. улс, хот хооронд, орон нутагт зорчихдоо иргэний үнэмлэх, холбогдох бусад баримт бичгийг биедээ авч явах, тэдгээрийг жолооч, кондуктор болон шалгах эрх бүхий хүмүүсийн анхны шаардлагаар үзүүлэх;

16.2.5. хуульд заасан бусад үүрэг.

17 дугаар зүйл. Нийтийн зорчигч тээврийн төлбөрийн цахим систем

17.1. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд төлбөрийн цахим систем ашиглаж болно.

17.2. Энэ хуулийн 17.1-д заасан төлбөрийн цахим картын систем улсын хэмжээнд нэгдмэл байна.

17.3. Төлбөрийн цахим системийг нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монгол банк, Санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөж батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Ачаа тээвэрлэлт

18 дугаар зүйл. Ачаа тээвэрлэгчийн үүрэг

18.1. Ачаа тээвэрлэгч нь энэ хуулийн 13.1-д заасан нийтлэг шаардлагаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

18.1.1. ачаа тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан зориулалтын автотээврийн хэрэгслээр аюул, осолгүй тээвэрлэх;

18.1.2. тусгай зориулалтын авто замаар тээвэрлэлт гүйцэтгэх журмыг Засгийн газар батална.

18.1.3. аюултай ачаа тээвэрлэх техникийн нөхцлийг стандартаар тогтооно.

18.1.4. аюултай ачааг хүн, мал амьтан болон өөр бараа бүтээгдэхүүнтэй хамт тээвэрлэх, шуудан тээвэр, нийтийн тээвэр, суудлын автомашин, ердийн хөсгөөр тээвэрлэхийг хориглоно.

18.1.5. гол, нуурын мөсөн дээгүүр зөвхөн тогтоосон хугацаанд батлагдсан чиглэлийн дагуу тээвэр хийж болно.

18.1.6. гол, нуурын мөсөн дээгүүр тээвэр хийх хугацаа, чиглэл, замналыг тухайн аймгийн Засаг дарга батална.

19 дүгээр зүйл. Тээвэрлүүлэгчийн эрх, үүрэг

19.1. Тээвэрлүүлэгч нь дараах эрхтэй:

19.1.1. ачаа тээвэрлэлтийн гэрээ болон ачааны дагалдах хуудаст заасан ачаа бараа дутах, түүний шинж чанар алдагдсан, тээвэрлэлтээс үүдэн гарсан бусад хохирлыг нэхэмжлэх;

19.1.2. тээвэрлэлтийн үнэ тариф, замын чиглэл, явцын талаарх үнэн зөв мэдээллээр хангагдах;

19.1.3. ачаа тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангаагүй, зориулалтын бус тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхээс татгалзах.

19.2. Тээвэрлүүлэгч нь дараах үүрэг хүлээнэ.

19.2.1. ачааны савлалт, баглаа, боодол, бэхэлгээг стандартын дагуу хийж, нэр төрөл, илгээх чиглэлээр нь ялган тээвэрлэхэд бэлтгэсэн байх;

19.2.2. ачааг ачих, буулгах зам, талбайг автотээврийн хэрэгсэл явахад саад учруулахгүй байх;

19.2.3. ачих, буулгах машин механизм, нэмэгдэл төхөөрөмж, хүн хүчийг бэлэн байлгаж ачааг тогтоосон хугацаанд ачих, буулгах, өөрийн хаягтай буюу гэрээт ачааг хүлээн авах;

19.2.4. ачааг тээвэрлэх, хадгалах тухай мэдээллээр тээвэрлэгчийг хангах;

19.2.5. ачаа хүлээн авсан тухайгаа тээврийн баримт бичигт тэмдэглэж баталгаажуулан тээвэрлэгчид олгох;

19.2.6. хуульд заасан бусад үүрэг.

ТАВДУГААР БҮЛЭГ

Автотээврийн терминал

20 дугаар зүйл. Автотээврийн терминал

20.1. Автотээврийн терминал нь үйлчилгээний төрлөөс хамааран дараах төрөлтэй байна:

20.1.1. зорчигчийн

20.1.2. ачааны

20.1.3. ачаа, зорчигчийн хосолсон

20.2. Автотээврийн терминал нь үйлчлэх хүрээнээсээ хамааран Олон улсын, бүс нутгийн, орон нутгийн гэсэн төрөлтэй байна.

20.3. Тээвэрлэлтийг терминалиар дамжуулан гүйцэтгэнэ.

20.3. Автотээврийн терминалийн байршлыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

20.4. Автотээврийн терминалийн үйл ажиллагаа, үйлчилгээнд тавигдах шаардлага, зэрэглэлийг стандартаар тогтооно.

20.5. Ачааны терминал нь өөрийн нэгдсэн сүлжээг ашиглан дотоодын, экспорт, импортын болон дамжин өнгөрөх ачааг хүлээн авах, хүлээлгэн өгөх, хадгалах, шилжүүлэн ачих, мэдээллийн сан бүрдүүлэх болон зохион байгуулалтын бусад үйлчилгээг үзүүлнэ.

20.6. Зорчигчийн терминал нь зорчигчид ая тухтай үйлчилгээ үзүүлэх, тээвэрлэлтийн үйлчилгээг оновчтой зохион байгуулах үйлчилгээг үзүүлнэ.

21 дүгээр зүйл. Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор

21.1. Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор нь жолооч, зорчигчид хэрэгцээт үйлчилгээг үзүүлэх болон техникийн шаардлагатай засвар үйлчилгээ, шатах тослох материалаар хангах үйлчилгээнүүдийг үзүүлнэ.

21.2. Авто замын дагуух үйлчилгээний цогцолборт тавигдах шаардлагыг стандартаар тогтооно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Автотээврийн хэрэгслийн ашиглалт

22 дугаар зүйл. Авто үйлчилгээ эрхлэгч

22.1. Авто үйлчилгээ эрхлэгч нь автотээврийн хэрэгслийн ашиглалт, найдвартай байдлыг хангахтай холбоотой дараах үйл ажиллагааг эрхлэн явуулна:

22.1.1. автотээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгсэл, тос тосолгооны материалын импорт, үйлдвэрлэл, худалдаа;

22.1.2. авто засвар үйлчилгээ;

22.1.3. техникийн үйлчилгээ;

22.1.4. автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой бусад үйлчилгээ.

22.2. Авто үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, ангиллыг стандартаар тогтооно.

22.3. Авто үйлчилгээ эрхлэгч дараах үүрэг хүлээнэ:

22.3.1. стандартаар тогтоосон шаардлагыг хангаж буй эсэхэд жил бүр тохирлын үнэлгээ хийлгэж баталгаажуулах;

22.3.2. стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжийг засвар үйлчилгээнд ашиглах;

22.3.3. хэрэглэгчдэд худалдах сэлбэг хэрэгсэл, тос, тосолгооны материал нь Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн гарал үүслийн гэрчилгээтэй байх.

23 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн бүртгэл

23.1. Автотээврийн хэрэгслийн бүртгэл нь улсын хэмжээнд нэгдмэл байна.

23.2. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл хөтлөх, бүртгэлийн дугаар олгох, бүртгэлээс хасах журмыг энэ хуульд нийцүүлэн автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

23.3. Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг автотээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага удирдан зохион байгуулна.

23.4. Импортоор орж ирсэн автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулан стандартын шаардлага хангасан тохиолдолд улсын бүртгэлд бүртгэж, дугаар олгоно.

23.5. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг, тэмдгийн үйлдвэрлэлд тавигдах шаардлагыг стандартаар тогтооно.

23.6. Автотээврийн хэрэгслийн бүртгэлийг улсын бүртгэгч бүртгэнэ. Бүртгэгч нь төрийн захиргааны албан хаагч байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Салбарын ажилтны давтан болон мэргэжлийн зэрэг олгох сургалт

24 дүгээр зүйл. Зөвлөх ба мэргэшсэн инженер

24.1. Салбарын ажилтны давтан сургалт, мэргэжлийн зэрэг дэв олгох журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.2. Мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний жагсаалтыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25 дугаар зүйл. Мэргэшсэн жолоочийн үнэмлэх

25.1. Мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтыг амжилттай дүүргэсэн суралцагчид мэргэшсэн жолоочийн үнэмлэх олгоно.

25.2. Мэргэшсэн жолоочийн үнэмлэхийн загвар, олгох журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25.3. Мэргэшсэн жолоочийн үнэмлэх нь тухайн ангиллын автотээврийн хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэхийн хамт хүчинтэй.

26 дугаар зүйл. Мэргэшсэн жолоочийн эрх дуусгавар болох

26.1. Мэргэшсэн жолоочийн эрх дор дурдсан тохиолдолд дуусгавар болно:

26.1.1. мэргэшсэн жолоочийн үнэмлэхийн хүчинтэй хугацаа дууссан;

26.1.2. замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмыг зөрчсөн зөрчлийн нийлбэр нь зөвшөөрөгдсөн хязгаараас хэтэрсэн;

26.1.3. автотээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийн хүчинтэй хугацаа дууссан, эсхүл бусад үндэслэлээр хүчингүй болсон.

26.2. Энэхүү хуулийн 26.1.2-т заасан зөрчлийг бүртгэх, нэгтгэн тооцох журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26.3. Мэргэшсэн жолоочийн эрх дуусгавар болсон нь тухайн ангиллын автотээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хүчингүй болгох, хасах үндэслэл болохгүй.

27 дугаар зүйл. Мэргэшсэн жолоочийн эрхийг түдгэлзүүлэх

27.1. Хуульд заасан үндэслэлээр автотээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хассан тохиолдолд тухайн этгээдийн мэргэшсэн жолоочийн эрхийг түдгэлзүүлнэ.

27.2. Энэ хуулийн 27.1-д заасан шалтгаан арилсан нөхцөлд мэргэшсэн жолоочийн эрхийг сэргээнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Автотээврийн мэдээллийн нэгдсэн сан

28 дугаар зүйл. Автотээврийн мэдээллийн нэгдсэн сан

28.1. Автотээврийн мэдээллийн нэгдсэн сан нь дор дурдсан дэд сангаас бүрдэнэ:

28.1.1. автотээврийн хэрэгслийн мэдээллийн сан;

28.1.2. жолооч, мэргэшсэн жолоочийн мэдээллийн сан;

28.1.3. ачаа тээврийн мэдээллийн сан;

28.1.4. нийтийн зорчигч тээврийн мэдээллийн сан;

28.1.5. автотээврийн хяналтын мэдээллийн сан.

28.1.6. автоүйлчилгээний мэдээллийн сан

28.2. Энэ хуулийн 28.1-д заасан дэд сан нь дор дурдсан мэдээллээс бүрдэнэ:

28.2.1. автотээврийн хэрэгслийн мэдээллийн санд автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл, устгал, техникийн хяналтын үзлэг, техникийн үйлчилгээтэй холбогдсон бусад мэдээлэл;

28.2.2. мэргэшсэн жолоочийн мэдээллийн санд мэргэшсэн жолооч бэлтгэх сургалт эрхлэх байгууллага, мэргэшсэн жолооч нарын нэгдсэн бүртгэл, тэдгээрт эрх олгосон ангилал, хүчинтэй хугацаатай холбогдсон мэдээлэл;

28.2.3. ачаа тээврийн мэдээллийн санд ачаа тээврийн тоо хэмжээ, давтамж, хамрах хүрээ, төрөл, ангилал болон автотээврийн терминалын үйл ажиллагаатай холбогдсон мэдээлэл;

28.2.4. нийтийн зорчигч тээврийн мэдээллийн санд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний цагийн хуваарь, үнэ тариф, чиглэл, автотээврийн хэрэгслийн байршил, хөдөлгөөнийг тодорхойлох, зохицуулах, цаг агаар, байгалийн гамшигтай холбогдсон мэдээлэл болон зорчигч тээвэртэй холбогдсон статистик мэдээлэл;

28.2.5. автотээврийн хяналтын мэдээллийн санд автотээврийн үйл ажиллагаанд гарсан зөрчил, тэдгээрт хийсэн эрсдэлийн үнэлгээ, хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд тавих хяналт шалгалттай холбогдсон мэдээлэл.

28.2.6 автоүйлчилгээний мэдээллийн сан автотээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний үйлчилгээний мэдээлэл.

28.3. Энэ хуулийн 28.1-д заасан санг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлнө.

28.4. Энэ хуулийн 28.1-д заасан санг бүрдүүлэх, баяжуулах, сангийн мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр нийтэд мэдээлэх журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.5. Энэ хуулийн 28.1-д заасан сан нь гааль, татвар, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сүлжээтэй уялдсан байна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Автотээврийн талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

29 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

29.1. Монгол Улсын Их Хурал автотээврийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.1.1. автотээврийн талаар төрөөс баримтлах бодлого тодорхойлох;

29.1.2. өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар олон улсын автотээврийн холбогдолтой гэрээ соёрхон батлах;

29.1.3. автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах.

30 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

30.1. Засгийн газар автотээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.1.1. автотээврийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, автотээврийн оновчтой дэд бүтэц, тээврийн үр ашигтай нэгдсэн сүлжээ, терминалыг хөгжүүлэх;

30.1.2. автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

30.1.3. автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих захиргааны хяналтыг хэрэгжүүлэх, автотээврийн хяналтын дүрмийг батлах;

30.1.4. автотээврийн хэрэгслийн төрөл, зориулалтыг нь харгалзан техникийн хяналтын үзлэгт оруулах төлбөрийн жишгийг ялгавартай тогтоох;

30.1.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

31 дүгээр зүйл. Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

31.1. Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.1.1. автотээврийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Ерөнхийлөгч, Улсын Их хурал, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

31.1.2. автотээврийн салбарт шинэ дэвшилтэт техник, технологи нутагшуулах, автотээврийн салбарын хүний нөөцийг бэлтгэн мэргэшүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх;

31.1.3. автотээврийн салбарын хөрөнгө оруулалтыг нийгэм-эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэн төлөвлөх;

31.1.4. автотээврийн салбарт мөрдөх дүрэм, журам, норм, норматив, аргачлалыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах;

31.1.5. улсын авто замын сүлжээ, төлөвлөлттэй уялдуулан олон улсын болон улсын чанартай авто замын дагуух автотээврийн терминал, замын дагуух үйлчилгээний цогцолборын байршлыг тогтоох;

31.1.6. тээвэрлэлтийн зай, ачааны төрлөөс хамааруулж ачаа, зорчигч тээврийн жишиг үнэ, үнэ тооцох аргачлалыг батлах;

31.1.7.автотээврийн салбарын инженер, техникийн ажилтны мэргэжлийг дээшлүүлэх, зэрэг олгох, давтан сургах журмыг батлах;

31.1.8. Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрмийг энэ хуульд нийцүүлэн батлах;

31.1.9. Тээвэрлэлтийн үйлчилгээ эрхэлж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн хөдөлмөр амралтын горимыг тогтоох;

31.1.10. улс хоорондын тээвэрлэлт болон Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ачаа тээвэрлэх үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор гадаад улс, олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллах;

31.1.11. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

32 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

32.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга автотээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1.автотээврийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газар болон автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

32.1.2.автотээврийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлоготой уялдуулан харьяалах нутаг дэвсгэртээ автотээврийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

32.1.3.орон нутгийн чанартай авто замын дагуух автотээврийн терминал, замын дагуух үйлчилгээний цогцолборын байршлыг тогтоох, барьж байгуулах зориулалтаар газар өмчлөх, эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

32.1.4. орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, цаг үеийн шуурхай тээврийг улсын захиалга, даалгаврын дагуу нутаг дэвсгэртээ хариуцан зохион байгуулах, зохицуулах;

32.1.5.хүн амын нутагшил, байршлын онцлог, зорчигч тээврийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй чиглэлд орон нутагт зорчигч тээврийг зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгээр тээвэрлэгчтэй гэрээ хийж гүйцэтгүүлэх асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

32.1.6.тухайн нутаг дэвсгэрт орших гол, мөрнийг автотээврийн хэрэгслээр гатлах гармыг тэмдэгжүүлэх;

32.1.7.тухайн нутаг дэвсгэрт орших гол, мөрөн, нуурын ус хөлдсөн үед орон нутгийн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллага, автозамын байгууллагатай хамтран мөсний даацыг тодорхойлж, орон нутгийн цаг уурын байдлыг харгалзан мөсөн дээгүүр хийх тээврийн эхлэх, дуусах хугацаа, чиглэлийг тогтоон тэмдэгжүүлж тээвэрлэгчдийг мэдээллээр хангах;

32.1.8.нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хараагүй хүнд зориулж буудлыг зарлах, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулж буудал бүрд нэр, хаяг, чиглэлийг бичмэл болон зургийн хэлбэрээр байрлуулах, өөрчлөх арга хэмжээг зохион байгуулах.

32.1.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

АРАВДУГААР БҮЛЭГ

Автотээврийн стандартчилал

33 дугаар зүйл. Стандартчилал

33.1.Автотээврийн стандартыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж, стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Тусгай зөвшөөрөл

34 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл

34.1. Дор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлж болно:

34.1.1. нийтийн зорчигч тээвэр;

34.1.2. автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах;

34.1.3. автотээврийн хэрэгсэл, түүний эд ангийн үйлдвэрлэл.

34.2. Энэ хуулийн 34.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дор дурдсан байгууллага, албан тушаалтан олгоно.

34.2.1. улс болон хот хоорондын нийтийн зорчигч тээвэр эрхлэх тусгай зөвшөөрлийг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

34.2.2. орон нутгийн нийтийн зорчигч тээвэр эрхлэх тусгай зөвшөөрлийг тухайн тээврийн чиглэл дайран өнгөрч байгаа аймаг, хотын Засаг дарга нар хамтран;

34.2.3. хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр эрхлэх тусгай зөвшөөрлийг тухайн хотын захирагч.

34.3. энэ хуулийн 34.1.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

35 дугаар зүйл. Нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

35.1. Нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тээврийн чиглэл тус бүрээр олгоно.

35.2. Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зөвхөн хуулийн этгээдэд олгоно.

35.3. Энэ хуулийн 35.2-т заасан сонгон шалгаруулалт явуулах журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

35.4. Тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллага нь нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах бөгөөд гэрээнд дараах зүйлийг тусгана:

35.4.1. үйлчилгээний цагийн хуваарь;

35.4.2. автотээвэр хийх чиглэл, давтамж;

35.4.3. талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага;

35.4.4. бусад асуудал.

36 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх үйл ажиллагаа эрхлэх

36.1. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх үйл ажиллагааг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан Монгол Улсын хуулийн этгээд эрхэлнэ.

36.2. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх хуулийн этгээд нь үйл ажиллагаандаа дараах шаардлагыг хангаж ажиллана:

36.2.1. автотээврийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэр, дүрэм, журам, заавар, стандартыг

мөрдөх;

36.2.2. автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартын дагуу хийж, техникийн аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан үйл ажиллагаа явуулах;

36.2.3. техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь стандартын үзүүлэлт, шаардлагыг хангасан эсэхийг стандарт, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаар тогтоосон хугацаанд жил бүр шалгуулж, баталгаажуулах;

36.2.4. эрх бүхий этгээд, улсын байцаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг хугацаанд нь биелүүлж хариу мэдэгдэх, илэрсэн зөрчлийг бүрэн арилгах арга хэмжээ авах.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэл

37 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэл

37.1. Монгол Улсад үйлдвэрлэсэн, угсарсан автотээврийн хэрэгсэл, агрегат, эд анги нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөөгүй байна.

38 дугаар зүйл. Автомашины эд ангийн устгал

38.1. Автомашины эд ангийн устгал хийх журмыг автотээврийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

38.2. Автомашины эд ангийн устгалыг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюултай нөхцөлд, зориулалтын бус газар, барилга байгууламжид явуулахыг хориглоно.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Автотээврийн хяналт

39 дүгээр зүйл. Автотээврийн хяналтыг хэрэгжүүлэх

39.1. Автотээврийн хяналтыг автотээврийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, стандарт, норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр хэрэгжүүлнэ.

39.2. Автотээврийн хяналтыг дор дурдсан байдлаар ангилна:

39.2.1. автотээврийн улсын хяналт;

39.2.2. тээврийн хэрэгслийн техникийн хяналт;

39.2.3. тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгчийн дотоод хяналт.

40 дугаар зүйл. Автотээврийн улсын хяналт

40.1. Автотээврийн улсын хяналтыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Улсын хяналтын алба, автотээврийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

40.2. Автотээврийн улсын хяналт нь автотээврийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, стандарт, норм, нормативын хэрэгжилтийг бүрэн хамарна.

41 дүгээр зүйл. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналт

41.1. Автотээврийн хэрэгслийн ашиглалтаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд энэ хуульд заасан журмын дагуу техникийн хяналтын үзлэг хийнэ.

41.2. Энэ хуулийн 41.3, 41.4-т зааснаас бусад тохиолдолд автотээврийн хэрэгслийг өмчлөгч, эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний автотээврийн хэрэгслийг хагас жил тутам, бусад автотээврийн хэрэгслийг жилд нэг удаа техникийн хяналтын үзлэгт хамруулна.

41.3. Шинэ автотээврийн хэрэгслийг эхний 2 жилд техникийн хяналтын үзлэгт хамруулахгүй.

41.4. Дараахь тохиолдолд энэхүү журмын 41.2, 41.3-т заасан хугацааг үл харгалзан автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулна:

41.4.1. хөдөлгүүр болон арлыг сольсон, өөрчилсөн, нэмэлт төхөөрөмж суурилуулсан, ажил үйлчилгээний шаардлагын дагуу **үйлдвэрлэгчийн зөвшөөрлөөр** автотээврийн хэрэгслийн зориулалтыг өөрчилсөн бол;

41.4.2. өмнө техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автотээврийн хэрэгсэлд зайлшгүй шаардлагаар засвар үйлчилгээ хийлгэсний дараа эзэмшигч нь хүсэлт гаргасан бол;

41.4.3. зам тээврийн осолд өртөж хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх агрегат, зангилаа, механизмд эвдрэл гарсан болон автотээврийн хэрэгслийг засварласан бол дахин замын хөдөлгөөнд оролцохын өмнө.

41.5. Ашиглагдаж байгаад импортоор орж ирсэн тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулж, стандартын шаардлага хангуулсны дараа улсын бүртгэлд бүртгэж, дугаар олгоно.

41.6. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

41.7. Техникийн хяналтын үзлэгийн гэрчилгээнд заасан хугацаанд техникийн хяналтын үзлэгт ороогүй автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг хориглоно.

41.8. Автотээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

41.8.1. Техникийн хяналтын үзлэгийн гэрчилгээнд заасан хугацаанд автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах;

41.8.2. Автотээврийн хэрэгсэл бүрийн техникийн баримт бичгийн бүрдлийг хангах.

41.8.3. Хууль тогтоомжид заасан бусад.

42 дугаар зүйл. Автотээврийн үйлчилгээ эрхлэгчийн дотоод хяналт

42.1. Автотээврийн үйлчилгээ эрхлэгч нь автотээврийн ажил, үйлчилгээ хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, стандарт, норм, нормативын дагуу явагдаж байгаа эсэхэд байнга хяналт тавьж ажиллана.

43 дугаар зүйл. Автотээврийн хяналтын улсын байцаагч

43.1. Автотээврийн хяналтын улсын ерөнхий байцаагч нь автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

43.2. Автотээврийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар, ахлах байцаагч, байцаагчийн эрхийг ерөнхий байцаагч тус тус олгоно.

43.3. Автотээврийн хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

43.3.1. автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ автотээврийн хэрэгслийг түр зогсоож шалгах, шаардлагатай гэж үзвэл тухайн автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, жолоодох эрхийн үнэмлэх, мэргэшсэн жолоочийн үнэмлэх, тээврийн баримт бичгийг уг зөрчлийг шийдвэрлэж дуустал түр хураах;

43.3.2. мэргэшсэн жолоочийн эрхийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх талаар эрх бүхий байгууллагад санал оруулах.

43.3.3. автотээврийн тухай хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрийн эрх мэдлийн хүрээнд авах;

43.3.4. автотээврийн тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах.

43.4. Автотээврийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч нь энэ хуулийн 44.3-т зааснаас гадна Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.12-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

43.5. Автотээврийн хяналтын улсын байцаагчийн хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд өгсөн үүрэг, тавьсан шаардлагыг холбогдох иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй.

43.6. Автотээврийн хяналтын улсын байцаагч нь албан үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгслээр хангагдана.

43.7. Автотээврийн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

44 дүгээр зүйл. Автотээврийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

44.1. Автотээврийн тухай хууль тогтоомжийг дараах байдлаар зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч болон автотээврийн хяналтын улсын байцаагч гэм буруутай этгээдэд дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

44.1.1. энэ хуулийн 13.1, 16.2, 19.2, 36.5 дахь заалтыг зөрчсөн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр торгох;

44.1.2. энэ хуулийн 7.2, 8.2, 10.3, 18.1.1, 18.1.4, 41.7, 41.8.1, 37.2 дахь заалтыг зөрчсөн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр торгох;

44.1.3. энэ хуулийн 24.2-д заасан ажил, үйлчилгээг мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлээгүй этгээдийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгож, тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг хураан авч улсын орлого болгон, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр торгох;

44.1.4. энэ хуулийн 34.1-д заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол үйл ажиллагааг нь зогсоож, тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг хураан авч улсын орлого болгон, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр торгох.

44.1.5. энэ хуулийн 36.1, 38.2-д заасныг зөрчсөн этгээдийг үйл ажиллагааг зогсоож, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр торгох.

44.2. Энэ хуулиар эрх олгогдсон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам болон мөн хуулийн 33.1-д заасан автотээврийн стандартыг зөрчсөн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр торгох шийтгэл ногдуулна.

44.3. Автотээврийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуулиар шийтгэл ногдуулсан нь түүнийг эрүүгийн болон бусад хууль зүйн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

45 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

45.1.Энэ хуулийг 2016 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ